



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/18

Өмнөдэлгэр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Наран багийн тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Гантогоо

Тархвар зүйч

Нарийн бичгийн дарга: Г.Нарангарав

Архив, бичиг хэргийн
ажилтан

Гишүүд: Д.Наранчимэг

Наран багийн Засаг
дарга

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангахыг үнэлгээний хорооны дарга (С.Гантогоо)-д даалгасугай.



Р.Энхтөр

232531003
D:\disk\bichig\hereg\zahiramj\